



Агаарын тээврийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисгэгчийн насны хязгаарлалтын талаар

Нисгэгчийн насны хязгаарлалтыг тогтоох ИCAO-гийн шаардлага нь зөвхөн **олон улсын** агаарын тээврийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисгэгчид хамааралтай бөгөөд орон нутгийн нислэгийн үйл ажиллагаанд Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн зөөлөн шаардлагыг тогтоох эрхтэй байдаг. Ж-нь: FAA - CPL 70 нас гэж тогтоосон бол бусад ихэнх улсууд орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд насны хязгаарлалт тогтоодоггүй.

Агаарын тээврийн үйл ажиллагаа / Air transport operation гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжин зорчигч, эсхүл барааг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх **шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ** (airline AOC) эзэмшигчийн үйл ажиллагааг ойлгоно.



Нисгэгчийн насны хязгаарлалтын талаарх өмнөх шийдвэрүүд

2010 оны ИНД-61.7-д:

- (в) 60-аас дээш настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь **олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын** үүрэг гүйцэтгэхгүй.
- (г) Хэрэв агаарын хөлгийн дарга нь 60-аас доош настай тохиолдолд 60-65 настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь **олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд хамтран нисгэгчийн** үүрэг гүйцэтгэж болно.

2011 оны Даргын А/134 дугаар тушаалд:

*Хөдөлмөрийн хорттой нөхцөлд хамаардаг ажил мэргэжлийн онцлогийг нь харгалзан, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 60 нас хүрч өндөр насны тэтгэврээ тогтоолгох эрх үүссэн хүмүүсийг 2011 оны 4 дүгээр сарны 01-ний өдрөөс эхлэн **арилжааны нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүнээр** оролцуулахгүй байхыг Агаар тээвэрлэгч нарт үүрэг болгосугай...*

- 2010 оны ИНД-61.7 нь А/134 тушаалтай зөрчилдөж байсан бөгөөд NZ Part 61-д нисгэгчийн насны хязгаарлалт байдаггүй тул 2019 оны шинэчлэн батлагдсан ИНД-61-д нисгэгчийн насны хязгаарлалт ороогүй.



Олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисгэгчийн насны хязгаарлалт

Монгол Улс нь 1999 оны УИХ-аар соёрхон баталсан Чикагогийн Конвенцид нэгдэн орсноор **олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд** оролцох нисгэгчийн насны хязгаарлалтыг дараах байдлаар хуульчилсан:

Чикагогийн конвенцийн Хавсралт 1. Үнэмлэх гэрчилгээжүүлэлт:

2.1.10. 60 нас хүрсэн нисгэгчийн эрхийг хязгаарлах ба 65 нас хүрсэн нисгэгчийн эрхийг дуусгавар болгох

Нисгэгчийн үнэмлэх олгосон Хэлэлцэн тохирогч улс нь **олон улсын арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд** оролцож байгаа үнэмлэх эзэмшигч нь хэрэв ганц нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд **60 нас** хүрсэн, эсхүл нэгээс олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд **65 нас** хүрсэн бол тухайн үнэмлэх эзэмшигчийг агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй байх.

Annex 1 - Personnel Licensing

2.1.10 Limitation of privileges of pilots who have attained their 60th birthday and curtailment of privileges of pilots who have attained their 65th birthday

A Contracting State, having issued pilot licences, shall not permit the holders thereof to act as pilot of an aircraft engaged in **international commercial air transport operations** if the licence holders have attained their **60th birthday** or, in the case of operations with more than one pilot, their **65th birthday**.



ICAO – Нисгэгчийн насны хязгаарлалт тогтоосон түүх



Background Pilot age limits – history

- 1919,
International Commission for Air Navigation (ICAN) - 45 years age limit
- 1947,
ICAO takes over from ICAN – no age limit in ICAO documentation
- 1963,
ICAO introduced age limit 60 based on the statistical data regarding the risk of sudden incapacitation
- 2006,
ICAO increased the age limit to 65 for multi-crew operations subject to the second member of the flight crew to be below the age of 60
- 2013,
ICAO proposed to abolish the '1 under, 1 over' policy



ICAO Annex 1 - Limitation of privileges of pilots

2006 Annex 1 - Amend. 167

2014 Annex 1 - Amend. 172

PIC: - **single** - 60 year
 - **multi** - 65 year (*Co-pilot is younger than 60*)

Pilot (PIC+Co-pilot): - **single** - 60 year
 - **multi** - 65 year

Co-pilot: - 65 year (*recommendation*)

2.1.10 Limitation of privileges of pilots who have attained their 60th birthday and curtailment of privileges of pilots who have attained their 65th birthday

2.1.10 Limitation of privileges of pilots who have attained their 60th birthday and curtailment of privileges of pilots who have attained their 65th birthday

2.1.10.1 A Contracting State, having issued pilot licences, shall not permit the holders thereof to act **as pilot-in-command** of an aircraft engaged in international commercial air transport operations if the licence holders have attained their 60th birthday **or, in the case of operations with more than one pilot where the other pilot is younger than 60 years of age, their 65th birthday.**

2.1.10.1 A Contracting State, having issued pilot licences, shall not permit the holders thereof to act **as pilot** of an aircraft engaged in international commercial air transport operations if the licence holders have attained their 60th birthday **or, in the case of operations with more than one pilot, their 65th birthday.**

2.1.10.2 **Recommendation.**— *A Contracting State, having issued pilot licences, should not permit the holders thereof to act as co-pilot of an aircraft engaged in international commercial air transport operations if the licence holders have attained their 65th birthday.*

Note.— Attention is drawn to 1.2.5.2.3 on the validity period of Medical Assessments for pilots over the age of 60 who are engaged in commercial air transport operations.

(Medical certificate validity is reduced to 6 months)



ICAO Annex 1 - Нисгэгчийн эрхийн хязгаарлалт

2006 Annex 1 - Өөрчлөлт 167

2014 Annex 1 - Өөрчлөлт 172

Хөлгийн дарга:

- ганц нисгэгч - 60 нас
- олон нисгэгч - 65 нас (хамтран нисгэгч нь 60-аас залуу байх)

Нисгэгч (Хөлгийн дарга+Хамтран нисгэгч):

- ганц нисгэгч - 60 нас
- олон нисгэгч - 65 нас

Хамтран нисгэгч: - 65 нас (зөвлөмж)

2.1.10 60 нас хүрсэн нисгэгчийн эрхийг хязгаарлах ба 65 нас хүрсэн нисгэгчийн эрхийг дуусгавар болгох

2.1.10 60 нас хүрсэн нисгэгчийн эрхийг хязгаарлах ба 65 нас хүрсэн нисгэгчийн эрхийг дуусгавар болгох

2.1.10.1 Нисгэгчийн үнэмлэх олгосон Хэлэлцэн тохирогч улс нь хэрэв үнэмлэх эзэмшигч нь 60 нас хүрсэн, эсхүл нэгээс олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд нөгөө нисгэгч нь 60 наснаас залуу хэдий ч 65 нас хүрсэн бол тухайн үнэмлэх эзэмшигчийг олон улсын арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

2.1.10.1 Нисгэгчийн үнэмлэх олгосон Хэлэлцэн тохирогч улс нь хэрэв үнэмлэх эзэмшигч нь 60 нас хүрсэн, эсхүл нэгээс олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд 65 нас хүрсэн бол тухайн үнэмлэх эзэмшигчийг олон улсын арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

2.1.10.2 Зөвлөмж.— Нисгэгчийн үнэмлэх олгосон Хэлэлцэн тохирогч улс нь хэрэв үнэмлэх эзэмшигч нь 65 нас хүрсэн бол тухайн үнэмлэх эзэмшигчийг олон улсын арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

Тайлбар.— Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 60-аас дээш настай нисгэгчийн Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг 1.2.5.2.3-ын дагуу тогтооно.

(Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг 6 сар болгож багасгасан)



The study recommendations

➤ Single pilot operations:

- Extend age limit of CAT pilots flying single pilot operations from 60 years to the pilot's 65th birthday.
- Extension of the age limit for single pilot operations should be accompanied by additional measures to reduce the likelihood of pilot incapacitation to meet current operational accident acceptability values.

➤ Multi pilot operations:

- Keep the age limit at 65 years as it is currently set by EASA (FCL.065; EASA, 2016).
- Use the same additional measures as for single pilots to reduce the likelihood of pilot incapacitation.



Нисгэгчийн насыг 60 - 65 болгож сунгасан үндэслэл

Pilots are prohibited by international rules for acting as the pilot on a Part 121 and Part 135 operations "engaged in international commercial air transport operations" if they have reached their 60th birthday (**single pilot**) or 65th birthday (**more than one pilot**).

While the ICAO report quoted in this article pre-dates the BMJ's study, it noted the following reasons for increasing the age limit from 60 to 65:

- Pilots are living longer
- Incapacitation training introduced in 1970s— since the upper age limit was introduced
- Modern aircraft are easier to fly than the pre-1970s vintage— Various protections in-built
- Because of these factors, it was concluded that the risk of an incapacitation-cause accident was less now than in the 1970s.

<https://simpleflying.com/commercial-pilot-retirement-age/#:~:text=%22The%20Standard%20limits%20the%20privileges,age%20for%20multi%2Dpilot%20operations.>



Шинэ-Зеланд - Нисгэгчийн насны хязгаарлалт

New Zealand issues Part 61 pilot licences for the lifetime of the holder. Continued validity is dependent on the holder meeting the continuing competency and medical standards appropriate to the licence.

The Human Rights Act (HRA) references prevent employment discrimination on the grounds of age. *(NZ AIP Gen 1.7)*

Шинэ-Зеланд нь Part 61-ээр нисгэгчийн үнэмлэхийг хугацаагүйгээр олгодог. Гэрчилгээ эзэмшигчийн үнэмлэхний хүчинтэй байдал нь түүний ур чадварын болон эрүүл мэндийн стандартыг хэрхэн байнга хадгалж байгаагаас шалтгаалдаг.

Хүний эрхийн тухай хуульд насаар үндэслэн ажилтныг гадуурхахыг хориглосон байдаг.

Тайлбар: NZ Part 61.15. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа:

(a) Энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэхийг **хугацаагүй** олгоно.

(A pilot licence issued i.a.w this Part is issued for the **lifetime** of the holder)

- Агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад нислэгийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь эрүүл мэндийн болон ур чадварын шаардлага хангаж байгаа бол үнэмлэх, зэрэглэлийн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно.



EASA - Нисгэгчийн насны хязгаарлалт

(COMMISSION REGULATION (EU) No 1178/2011)

FCL.065 Curtailment of privileges of licence holders aged 60 years or more in commercial air transport

(a) **Age 60-64.** *Aeroplanes and helicopters.* The holder of a pilot licence who has attained the age of 60 years shall not act as a pilot of an aircraft engaged in commercial air transport except:

(1) as a member of a multi-pilot crew; and

(2) provided that such a holder is the only pilot in the flight crew who has attained the age of 60 years.

(b) **Age 65.** The holder of a pilot licence who has attained the age of 65 years shall not act as a pilot of an aircraft engaged in commercial air transport.

FCL.065 Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 60, эсхүл түүнээс дээш настай үнэмлэх эзэмшигчийн эрхийн хязгаарлалт

(a) **60-64 нас.** *Нисэх онгоц болон нисдэг тэрэг.* 60-аас дээш настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд, арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй:

(1) олон нисгэгчтэй агаарын хөлгийн багийн гишүүн байх;

(2) тухайн нисэх багийн 60 нас хүрсэн цорын ганц гишүүн нь байх.

(b) **65-аас дээш настай** нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй.

(Тэмдэглэл: EASA нь олон улсын, орон нутаг гэж ангилалгүй, зөвхөн арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон.)



FAA - Нисгэгчийн насны хязгаарлалт - Англи

(FAR 61 Certification: Pilots, Flight Instructors, And Ground instructors)

§61.3 Requirement for certificates, ratings, and authorization

(j)(1) *Age limitation.* No person who holds a pilot certificate issued under this part may serve as a pilot on a civil airplane of U.S. registry in the following operations if the person has reached his or her **60th birthday** or, in the case of operations with more than one pilot, his or her **65th birthday**:

- (i) **Scheduled international air services** carrying passengers in turbojet-powered airplanes; *(ИНД-121)*
- (ii) **Scheduled international air services** carrying passengers in airplanes having a passenger-seat configuration of more than 9 passenger seats, excluding each crewmember seat; *(ИНД-125)*
- (iii) **Nonscheduled international air transportation** for compensation or hire in airplanes having a passenger-seat configuration of more than 30 passenger seats, excluding each crewmember seat; or *(ИНД-121)*
- (iv) **Scheduled international air services**, or **nonscheduled international air transportation** for compensation or hire, in airplanes having a payload capacity of more than 7,500 pounds (3410 kg). *(ИНД-121)*

*(Note: FAA did limitation only for **international air transportation**)*



FAA - Нисгэгчийн насны хязгаарлалт - Монгол

(FAR 61 Certification: Pilots, Flight Instructors, And Ground instructors)

§61.3 Үнэмлэх, зэрэглэл болон эрх олгох шаардлага

(j)(1) *Насны хязгаарлалт.* Энэ дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хэрэв **60 нас** хүрсэн, эсхүл нэгээс олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд **65 нас** хүрсэн бол дараах үйл ажиллагаанд оролцож байгаа АНУ-ын бүртгэлтэй иргэний нисэх онгоцонд нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй.

- (i) хуваарьт олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд турбо-жет нисэх онгоцоор зорчигч тээвэрлэх; (ИНД-121)
- (ii) хуваарьт олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд нисэх багийн гишүүний суудлаас гадна, 9-ээс дээш зорчигчийн суудлын конфигурацитай нисэх онгоцоор зорчигч тээвэрлэх; (ИНД-125)
- (iii) хуваарьт бус олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ашигладаг нисэх багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай нисэх онгоцны; эсхүл (ИНД-121)
- (iv) хуваарьт олон улсын агаарын тээврийн, эсхүл хуваарьт бус олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ашигладаг 7,500 lbs (3410 кг)-аас дээш төлбөрт ачааллын багтаамжтай нисэх онгоцны. (ИНД-121)

(Тэмдэглэл: FAA зөвхөн олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд хязгаарласан)



Монгол Улсын хууль, тогтоомж

❖ УИХ 1999 онд Монгол Улсын нэгдэн орсон Чикагогийн Конвенцийн дагуу **олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд** оролцох нисгэгчийн насны хязгаарлалтыг дараах байдлаар хуульчилсан:

Чикагогийн конвенцийн Хавсралт 1. Үнэмлэх гэрчилгээжүүлэлт 2.1.10:

60 нас хүрсэн нисгэгчийн эрхийг хязгаарлах ба 65 нас хүрсэн нисгэгчийн эрхийг дуусгавар болгох

Нисгэгчийн үнэмлэх олгосон Хэлэлцэн тохирогч улс нь **олон улсын арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанд** оролцож байгаа үнэмлэх эзэмшигч нь хэрэв ганц нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд **60 нас** хүрсэн, эсхүл нэгээс олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд **65 нас** хүрсэн бол тухайн үнэмлэх эзэмшигчийг агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй байх.

❖ МУ-ын Үндсэн хуулийн 4.2-т: “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, **нас**, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор **нь ялгаварлан гадуурхаж үл болно**”

❖ МУ-ын Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4.

Өндөр насны тэтгэвэр авах эрх 1-д: “*Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон **авах эрхтэй***” гэж заажээ.

❖ Захиргааны ерөнхий хуулийн 60.1. Захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна:

60.1.1. МУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх;

60.1.4. шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх; (Конвенци, ИНД, Тэтгэврийн, Захиргааны ерөнхий хууль)

60.1.6. хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;



ИСаО насны хязгаарлалтыг богиносгон тогтооход анхаарах хүчин зүйлс

- ❖ Нисгэгчийн насны хязгаарлалтыг богиносгон тогтооход хангалттай тооны Шалгагч, Багш болон ATP-ийг зохих ёсоор авсан нисгэгчийн нөөцтэй эсэх.
- ❖ 1990 оны эхээр АН-24/26 нисэх онгоцны 10 гаруй туршлагатай Шалгагч, Багш болон хөлгийн даргын эрхийг 60 насаар олноор зэрэг хязгаарласан нь **1990-2000 онуудад гарсан олон осол, сүйрлийн шалтгаан болсон.**
- ❖ 2006-2010 онуудад В727/737 нисэх онгоцны 10 гаруй туршлагатай Шалгагч, Багш болон хөлгийн даргын эрхийг олноор хязгаарласан нь **нислэгийн аюулгүй байдал болон нислэгийн тогтмолжилтод сөргөөр нөлөөлөх шалтгаан болсон.**
- ❖ Хувийн явцуу эрх ашигт хөтлөгдөн, туршлагатай нисгэгчдийн эрхийг эрт хязгаарлах, судалгаа, үндэслэлгүй шийдвэр гаргах нь осол сүйрлийн эрсдэлийг нэмэгдүүлэх аюултай болохыг **НТОЗШША-ны** сүүлийн жилүүдэд гаргасан **осол, ноцтой зөрчлийн** тайланд тусгасан.
- ❖ ИНД-121.805-д зааснаар агаарын хөлгийн 1 нисэх баг жилд 1000 цаг нисэх боломжтой бөгөөд МИАТ 30 нисэх багтай (60 нисгэгч) гэж үзвэл жилд 30'000 цаг нисэх боломжтой байтал оргил 2018 онд 14'000 орчим цагийн нислэг үйлджээ.
- ❖ Нисгэгчийг ниссэн цагаар нь цалинжуулдаг цалингийн тогтолцоо нь буруу бөгөөд ОУ-д нислэгийн аюулгүй байдлын үндэслэлээр нисгэгчийн цалин нь тогтмол байдаг.
- ❖ Иргэний нисэхийн салбарт МИАТ-аас бусад бүх агаарын тээвэрлэгчид туршлагатай нисгэгчийн хомсдолд орж, ИНД-ийн шаардлага хангаагүй нисгэгчдийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- ❖ ATP-г ИНД зөрчсөн, хялбаршуулсан замаар олгож байгааг НТОЗШША-наас удаа дараа анхааруулж байсан.



Бусад улсад насны хязгаарлалт тогтоосон байдал

- ❖ Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцох нисгэгчийн насны хязгаарлалтыг Чикагогийн конвенцид нийцүүлэн, АНУ болон ЕХУ зэрэг бусад Хэлэлцэн тохирогч ихэнх улсууд 65 насаар тогтоосон.
 - EASA: The holder of a pilot licence who has attained the age of **65 years** shall not act as a pilot of an aircraft engaged in commercial air transport.
 - FAA: No person may serve as a pilot if the person has reached his or her **60th birthday** or, in the case of operations with more than one pilot, his or her **65th birthday**.
- ❖ Дараах улсууд насны хязгаарлалтыг ICAO-гийн шаардлагаас дээгүүр тогтоосон, эсхүл огт тогтоогүй:
 - Canada **does not restrict** the privileges of pilots who have attained their 60th birthday or curtail the privileges of pilots who have attained their 65th birthday.
 - Australia and New Zealand **the state law forbids discrimination on the grounds of age**. Continued validity is dependent on the holder meeting the continuing **competency and medical standards** appropriate to the licence.
 - Japan CAA has raised the mandatory retirement **age to 68** in March 2015.



ИНД-ээр нисгэгчийн насанд хязгаарлалт тогтоох санал

Агаарын тээврийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нисгэгчийн насны хязгаарлалтыг Конвенци, МУ-ын үндсэн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нийцүүлэн ИНД-61-т дараах байдлаар оруулах нь зүйтэй гэж агаарын тээвэрлэгчидтэй зохион байгуулсан хэлэлцүүлгээр санал нэгтэй шийдвэрлэсэн.

61.15А. Агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 60, эсхүл түүнээс дээш настай нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн эрхийн хязгаарлалт

(a) **60 нас хүрсэн** нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь **ганц-нисгэгчтэй агаарын тээврийн үйл ажиллагаанд** ашиглаж байгаа агаарын хөлөгт хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхгүй.

(b) **65 нас хүрсэн** нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь **олон-нисгэгчтэй агаарын тээврийн үйл ажиллагаанд** ашиглаж байгаа агаарын хөлөгт нисгэгчийн үүрэг гүйцэтгэхгүй.

67.61. Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа

(a) Энэ зүйлийн (c) болон (e)-г харгалзан, Дарга ЭМГ-г дараах хугацаагаар олгож болно:

(1) 1-р ангиллын ЭМГ:

(ii) 6 сар хүртэлх хугацаагаар, хэрэв хүсэлт гаргагч нь ЭМГ олгох үед 60, эсхүл түүнээс дээш настай бол; эсхүл (*Annex 1 1.2.5.2.3*)



ИНД-ээр нисгэгчийн насыг хязгаарлах санал (үргэлжлэл)

К Бүлэг - Багийн гишүүдийн ажил, амралтын цагийн зохицуулалт

121.805. Нисэх багийн гишүүний үүрэг хариуцлага

(d) Хэрэв нислэг эхлэхэд, тухайн этгээдийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны өмнөх болон төлөвлөсөн нислэгийн нийт цаг нь дараах хязгаарлалтаас хэтэрсэн бол, тухайн этгээд нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нисэх онгоцны нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй байх үүрэгтэй:

(1) тухайн нислэг эхлэх өдрийг багтаасан дараалсан 28 хоногт - 100 цаг; эсхүл

(2) тухайн нислэг эхлэх өдрийг багтаасан дараалсан 365 хоногт - 1000 цаг.

(3) 60-аас дээш настай нисгэгчийн хувьд, энэ зүйлийн (d)(1), (2)-т заасан хязгаарлалтын 80%-аас илүүгүй байна. (ИНД-125-д адил)

Тайлбар: 2019 оны ИНД-61.15. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа.

(a) Энэ Дүрмийн дагуу олгодог нисгэгчийн үнэмлэхийг **хугацаагүй** олгоно.

(A pilot licence issued i.a.w this Part is issued for the **lifetime** of the holder)

Агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад нислэгийн үйл ажиллагааны хувьд, ур чадварын болон эрүүл мэндийн шаардлагыг хангаж байгаа тохиолдолд нисгэгчид насны хязгаарлалт тогтоохгүй.